

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын баг



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГТ
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:ХОА-2021/116/ШТА-ГА

Ховд хот

2021 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:99013699 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас: 70432545 Цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn

Аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас:7043-2545 Цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn

Аудитор: Ц.Аззаяа

Утас:7043-2545 Цахим хаяг: azzayats@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар..... 3

Хүснэгтийн товъёг..... 3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....4-5

БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөн холбогдох хууль, журмыг зөрчин, баталжээ.6-7

БҮЛЭГ 2. Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, хэрэгжилтийн явцын тайланг дээд шатны байгууллагад хүргүүлж үр дүнг хэлэлцээгүй, хөрөнгө оруулалтын ажлууд нь үр дүнтэй болоогүйгээс төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөж буурч байна......8-17

БҮЛЭГ 3. Захиалагчийн зүгээс хөрөнгө оруулалтын ажлуудад хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс чанаргүй ажлууд хийгдэж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулжээ......17-20

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг салбарын болон орон нутгийн бодлогод нийцүүлэн төлөвлөж хууль журмын дагуу зохион байгуулаагүй, мэргэжлийн байгууллагуудын хяналт сулаас зарим төсөл арга хэмжээ хангалтгүй хэрэгжсэн байна......20

ЗӨВЛӨМЖ:.....20-21

ХАВСРАЛТУУД:.....

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын их хурал
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗД	Засаг дарга
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төсрийн өмчит үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	6

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/15 тоот тогтоолоор баталсан “Аудитын сэдэв батлах тухай”, “Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Аймгийн ИТХ, Аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➢ Орон нутгийн хөрөнгө оруулалтыг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх ➢ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтыг үр дүнтэй зарцуулсан эсэх ➢ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын дотоод хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС, Хөшөөт хөгжил сан, Жаргалант сумын ОНХС, Жаргалант сумын ОНХО-гийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд батлагдсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, аймгийн ЗДТГ, сум, байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:	Аудитыг Ховд аймгийн аудитын газрын дарга тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн явцын хяналт тавьж, ахлах аудитор Д.Мөнхтулга, аудитор Д.Эрдэнэцэцэг Ц.Аззаяа нар 2021 оны 05-р сарын 15-наас 09-р сарын 20-ныг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв. Аудитын хугацаанд Ховд аймагт Ковид-19 халдварын тархалт нэмэгдэж шалгагдагч байгууллагуудын албан хаагчид болон шалгасан аудиторууд өвчилсөн, шалгагдагч байгууллагуудаас хариу тайлбар ирээгүй зэргээс хамаарч аудитын хугацаа хойшлогдлоо. Орон нутгийн хөрөнгө оруулалтыг хууль, журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан эсэх талаар I бүлэгт, Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаар II бүлэгт, Орон нутгийн хөрөнгө оруулалтад дотоод хяналтыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар III бүлэгт тус тус тайлагнаж зөвлөмж хүргүүлэв.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аймгийн ИТХ-ын 2019 оны 06-р сарын 17-ны өдрийн 9 дүгээр хуралдааны 9/03 дугаар тогтоолоор **ОНХО-ын** 2019 оны төсвийг шинээр эхлэх хөрөнгө оруулалт 75.0 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авах 185.0 сая төгрөг, их засварт 420.0 сая төгрөг нийт 680.0 сая төгрөгөөр, ИТХ-ын 2020 оны 9-р сарын 15-ны 11-р хуралдааны 11/02 тоот тогтоолоор 2020 оны төсвийг тоног төхөөрөмж худалдан авах 415.5 сая төгрөг, их засварт 195.6 сая төгрөг нийт 611.1 сая төгрөгөөр тус тус төсвийг баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 11-р хуралдааны 11/02 тоот тогтоолоор 2020 оны **ОНХС-ийн** төсвийг шилжих хөрөнгө оруулалтаар 6 ажлын 799.1 сая төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 33 ажлын 1735.6 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авах 9 ажил болох 559.5 сая төгрөг, их засварын 52 ажлын 1848.4 сая төгрөг, төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардал болох 36 ажилд 1175.5 сая төгрөг өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 293.3 сая төгрөг нийт 6411.4 сая төгрөгийн хөрөнгө санхүүжүүлэхээр баталсан байна.

ИТХ-ын 2020 оны 9-р сарын 15-ны 11-р хуралдааны 11/02 тоот тогтоолоор **Хөшөөт хөгжил сангийн** 2019 оны төсвийг шинээр эхлэх хөрөнгө оруулалт 211.0 сая, тоног төхөөрөмж худалдан авахад 567.0 сая, их засварт 267.5 сая, төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 438.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 11-р хуралдааны 11/02 тоот тогтоолоор Хөшөөт хөгжил сангийн 2020 оны төсвийг шинээр эхлэх хөрөнгө оруулалт 666.0 сая, тоног төхөөрөмж худалдан авахад 512.1 сая, их засварт 833.0 сая, төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 297.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталжээ.

Засаг даргын захирамжаар 2020 онд ажлын хэсэг байгуулах тухай 276, хөрөнгө гаргах тухай 265, эрх шилжүүлсэн 61, зөвшөөрөл олгох тухай 36, буцалтгүй тусламж олгох тухай 26, бусад асуудлаар 26 захирамж нийт 870 захирамж гаргасан байна.

2019 онд ОНХО-ын орлогыг 1616.1 сая төгрөг байхаар баталсан ч гүйцэтгэлээр 843.5 сая төгрөгийн санхүүжилтийг авч 939.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг санхүүжүүлжээ. 84.8 сая төгрөгийг 2 шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажилд, 290.5 сая төгрөгийг 11 тоног төхөөрөмж худалдан авахад, 468.3 сая төгрөгийг 11 их засварын ажилд, өмнөх оны үлдэгдлээс 96.1 сая төгрөгийн 8 ажилд зарцуулжээ.

2020 онд ОНХО-ын орлогыг 1132.0 сая төгрөгөөр баталсан ч гүйцэтгэлээр 915.6 сая төгрөгийн санхүүжилт авч 962.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлжээ. 613.6 сая төгрөгийн 15 тоног төхөөрөмж худалдан авч 302.3 сая төгрөгийн 9 их засварын ажлыг санхүүжүүлж өмнөх оны үлдэгдлээс 46.2 сая төгрөгийн 2 ажлыг санхүүжүүлжээ.

2019 онд Хөшөөт хөгжил сан нь 1264.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж 1508.8 сая төгрөгийн 43 төсөл, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлжээ.

2020 онд 1234.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж 1293.9 сая төгрөгийн 46 төсөл, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлжээ.

БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөн холбогдох хууль, журмыг зөрчин, баталжээ.

Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй төсөл арга хэмжээг төлөвлөн баталжээ.

1.1 Орон нутгийн төсвийн, ОНХС, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг, 2019, 2020 оны төсвийн тухай хуульд тусгуулахдаа "2019, 2020 онд эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл", "Ховд аймгийг 2010-2025 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө", аймгийн ИТХ-ын хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 2/03 тоот тогтоолоор баталсан Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг биелүүлэхэд чиглэгдсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг үндэслэн орон нутгийн хэрэгцээ, тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

№	Нэрс	Он	ОНХО		ОНХС		Хөшөөт хөгжил сан	
			Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	2019	9	312.0			4	211.0
2	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	2020			39	2,534.7	16	666.0
3	Тоног төхөөрөмж	2019	17	458.7			19	567.0
4	Тоног төхөөрөмж	2020	22	765.2	9	559.5	22	512.1
5	Их засвар, тохижилт	2019	22	677.8			11	267.5
6	Их засвар, тохижилт	2020	9	320.6	52	1,848.4	16	833.0
7	Төсөл арга хэмжээ	2019					17	438.3
8	Төсөл арга хэмжээ	2020			36	1,175.5	12	297.2
9	Өмнөх оны үлдэгдлээс	2019	10	167.6			7	60.0
10	Өмнөх оны үлдэгдлээс	2020	5	46.2	12	293.3		
	2019 оны дүн		58	1616.1	0	0	58	1543.8
	2020 оны дүн		36	1132.0	148	6,411.4	66	2308.3

2019 онд Хөшөөт хөгжил сан болон ОНХО-таар нийт 116 ажлын 3159.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. Үүнээс шинээр эхлэх 13 төсөл арга хэмжээнд 523.0 сая төгрөг, 36 тоног төхөөрөмж худалдан авахад 1025.7 сая төгрөг, 33 их засвар, тохижилтын ажилд 945.3 сая төгрөг, 17 төсөл арга хэмжээнд 438.3 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 17 ажлын 227.6 сая төгрөгийг хуваарилжээ.

2020 онд Хөшөөт хөгжил сан, ОНХО, ОНХС-гаар нийт 250 ажлын 9851.7 сая төгрөгийн санхүүжилтийг баталжээ. Үүнээс шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 55 ажилд 3200.7 сая төгрөг, 53 тоног төхөөрөмж худалдан авахад 1836.8 сая төгрөг, 77 их засвар, тохижилтын ажилд 3002.0 сая төгрөг, 48 төсөл арга хэмжээнд 1472.7 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 17 ажлын 339.5 сая төгрөг хуваарилжээ.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2020 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 3 ажилд 43.0 сая, тоног төхөөрөмжийн 1 ажилд 10.0 сая, их засвар тохижилтын 3 ажилд 73.7 сая, төсөл хөтөлбөр арга хэмжээний 3 ажилд 74.8 сая, бүгд 201.5 сая төгрөг баталжээ.

Замын сангийн хөрөнгөөр 2020 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 3 ажилд 365 сая, их засвар тохижилтын 12 ажилд 370.0 сая, төсөл хөтөлбөр арга хэмжээний 1 ажилд 15.0 сая, бүгд 750.0 сая төгрөг баталжээ.

2019-2020 онуудад хөрөнгө оруулалтын шинж чанаргүй 39 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 735.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан нь Төсвийн тухай хууль болон ОНХС-гийн журамтай нийцэхгүй байна.

Жаргалант сумын ОНХС-гийн төсвийг 2020 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалт 185.8 сая, тоног төхөөрөмж худалдан авахад 9.0 сая төгрөг, их засварт 19.0 сая, төсөл, хөтөлбөр арга хэмжээнд 48.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталжээ.

Жаргалант сумын ОНХО-ийн төсвийг 2020 онд 89.8 сая, тоног төхөөрөмж худалдан авахад 41.5 сая, их засварт 6.0 сая, төсөл хөтөлбөр, арга хэмжээнд 84.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталжээ

ИТХ-аар хөрөнгө оруулалтын төсөө батлуулахдаа Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоол болон Сангийн сайдын журмыг зөрчин иргэдийн санал аваагүй хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр батлуулжээ.

1.2 Иргэдийн хэрэгцээ шаардлага хангаагүй, зураг төсөвгүй, техник эдийн засгийн тооцоо судалгаа хийгдээгүй, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй, иргэдийн санал аваагүй ажлыг санхүүжүүлэхээр баталжээ.

2019 онд Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 310.5 сая төгрөгийн 16 төсөл хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр, 2020 онд Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 233.2 сая төгрөгийн 7 төсөл хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹ дахь заалттай нийцэхгүй байна. Тухайлбал: Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах хөтөлбөрт 2019, 2020 онуудад Хөшөөт хөгжил сангаас тус бүр 80.0 сая төгрөгийг олгохоор баталжээ. 2020 онд Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр Төрийн үйлчилгээнд ISO 9001 стандартыг нэвтрүүлэх, “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 35.0 сая, Засгийн газрын 2010 оны 271 тоот тогтоолыг зөрчин 2019 онд баяр наадам тэмдэглэхэд Хөшөөт хөгжил сангаас 40.0 сая төгрөг, 2020 онд Хөшөөт хөгжил сангаас 30.0 сая төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Сангийн сайдын 2018 оны 228 дүгээр тогтоолын 4.1² дахь заалтыг зөрчин 2020 онд аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 1175.5 сая төгрөгийн 36 төсөл хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталжээ.

2020 онд ОНХО-ын орлогыг 1132.0 сая төгрөгөөр баталсан ч гүйцэтгэлээр 915.6 сая төгрөгийн санхүүжилт авч 962.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлжээ. 613.6 сая төгрөгийн 15 тоног төхөөрөмж худалдан авч 302.3 сая төгрөгийн 9 их засварын ажлыг санхүүжүүлж өмнөх оны үлдэгдлээс 46.2 сая төгрөгийн 2 ажлыг санхүүжүүлжээ.

¹ Хөрөнгө оруулалтын төсөөт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

² Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан чиг үүрэгт хамаарах энэ журмын 4.2-т зааснаас бусад хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх ажлыг санхүүжүүлнэ.

БҮЛЭГ 2. Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, хэрэгжилтийн явцын тайланг дээд шатны байгууллагад хүргүүлж үр дүнг хэлэлцээгүй, хөрөнгө оруулалтын ажлууд нь үр дүнтэй болоогүйгээс төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулжээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээг Ковид-19 цар тахалтай холбоотойгоор санхүүжүүлээгүй байна.

2.1.1 2019 онд ОНХО-ын орлогыг 1616.1 сая төгрөг байхаар баталсан ч гүйцэтгэлээр 843.5 сая төгрөгийн санхүүжилтийг авч 939.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг санхүүжүүлжээ. 84.8 сая төгрөгийг 2 шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажилд, 290.5 сая төгрөгийг 11 тоног төхөөрөмж худалдан авахад, 468.3 сая төгрөгийг 11 их засварын ажилд, өмнөх оны үлдэгдлээс 96.1 сая төгрөгийн 8 ажилд зарцуулжээ.

2020 онд ОНХО-ын орлогыг 1132.0 сая төгрөгөөр баталсан ч гүйцэтгэлээр 915.6 сая төгрөгийн санхүүжилт авч 962.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлжээ. 613.6 сая төгрөгийн 15 тоног төхөөрөмж худалдан авч 302.3 сая төгрөгийн 9 их засварын ажлыг санхүүжүүлж өмнөх оны үлдэгдлээс 46.2 сая төгрөгийн 2 ажлыг санхүүжүүлжээ. ОНХО-аар хийгдэх ажлууд нь тайланд онд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй, зохион байгуулсан ч шаардлага хангасан оролцогч иргээгүй, Ковид 19 цар тахалтай холбоотойгоор зарим төсөл арга хэмжээг санхүүжүүлээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтын ихэнх ажлууд чанарын шаардлага хангаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй, ажлын тоо хэмжээгээр хийгээгүй байна.

2.1.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 6411.4 мянган төгрөг батлагдсанаас 6119.3 мянган төгрөг зарцуулжээ.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын зарим ажлууд олон нийтийн эрх ашигт нийцсэн үр дүнтэй ажил хийгдсэн байна. Тухайлбал:

- Жаргалант сумын Баатархайрхан багт Богоч констракшн ХХК-ны гүйцэтгэсэн нийтийн саун, халуун ус, үйлчилгээний төв байгуулах,
- Жаргалант ургамал ХХК-ны Жаргалант сумын Баатархайрхан багийн өрхийн эмнэлгийг цэвэр бохир шугамтай холбох,
- Ховд ганган нуур ХХК-ны ЕБ-ийн 7 дугаар сургуулийн дотуур байрны зөөлөн эдлэл, ор, урлагийн заалны тохижилт,
- Чандмань суманд Гайхамшигт өнгө ХХК-ны Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх,
- Ланз ХХК-ны Ахмадын хорооны Цагаан уул төвийн барилгын сантехникийн төхөөрөмж суурилуулах,
- Эрдэнэбүрэн суманд хэрэгжүүлсэн Ундралт алт ХХК-ны сумын төвийн гэрэлтүүлгийг сайжруулах,
- Чандмань суманд хэрэгжүүлсэн Си Би Ай аутсорс ХХК-ны сумын төвийн гудамж талбайн тохижилт, гэрэлтүүлэг,
- Ховд баганат ХХК-ны 7 дугаар цэцэрлэгийн барилгын дээврийн засвар,
- Буянт голын зуслангийн бүсэд бие засах газар байгуулах,
- Бат-Арвижих ХХК-ны Зэрэг сумын Бургасан багийн айл өрхийг эрчим хүчинд холбох,
- Жаргалант сумын Бичигт, Тахилт, Наран, Рашаант, Алаг толгой, Буянт, Бугат багуудын нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалтын ажлууд зэрэг олон нийтийн эрх ашигт нийцсэн хөрөнгө оруулалтууд болсон байна.

2.1.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төсвийг ИТХ нь хуралдаанаар хэлэлцэхдээ иргэдээс гаргаагүй төсөл арга хэмжээг төлөөлөгчдийн тойргийн ашиг сонирхлоор оруулж баталдаг, батлагдаж байгаа арга хэмжээнд иргэд хяналтгүй, үр дүнг тооцоогүй нийтийн эрх ашигт нийцээгүй, үр ашиггүй, хэсэг бүлэг хүнд чиглэсэн хөрөнгө оруулалтууд батлагдаж хэрэгжсэн байна. Тухайлбал:

- Алтайн оргил констракшн ХХК-ны 48.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Жаргалант сумын Бичигт багт жишиг гудамж, Тэмүүлэх гал ХХК-ны Жаргалант сумын Хайрхан багт 148.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй жишиг гудамж байгуулах, Ховд шинэ асар ХХК-ны 97.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Жаргалант сумын Наран багийн жишиг гудамж тохижуулах ажил нь хувь иргэний эзэмшлийн хашааг нэгдсэн зохион байгуулалтгүй, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй газар сунгасан, иргэний хувь оролцоогүйгээр шинэчилж байгаа нь нийтийн эрх ашигт нийцээгүй зардал гаргасан, хөрөнгө орлого хаана авах нь тодорхой бус, төсвийн хөрөнгө үргүй зарцуулсан
- Буянт тэгш үйлс ХХК-ны Жаргалант сумын Буянт багийн хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил болох 28.3 сая төгрөгийн гүйцэтгэсэн ажил нь гэрээний үүргээ биелүүлээгүй, ажлын гүйцэтгэлийн хяналт хэрэгжээгүй, е-баримтгүй гүйлгээ хийсэн, ажлаа бүрэн хийж хүлээлгэн өгөөгүй, алданги тооцоогүй, чанарын шаардлага хангаагүй, тоо хэмжээ дутуу, зарим хийсэн ажил сайжруулах шаардлагатай төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан,
- Инжэд төр ХХК-ны Зэрэг сумын Гүвээ багт биеийн тамирын талбай байгуулж, хашаажуулах ажлын үүрэг даалгаврын биелэлтээр хяналт хэрэгжүүлээгүй, гүйцэтгэлийн дараах хяналт хийгээгүй, гүйцэтгэсэн ажлаа сайжруулах шаардлагатай, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан



2.1.4 Хөрөнгө оруулалтын чиглэлээр хэрэгжүүлэх зарим ажлууд нь урьдчилан тооцсон зураг, төсөвт өртөг байхгүй, шаардлага хангахгүй, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй, зарим ажил акт баримтаар баталгаажаагүй, орлого аваагүй, чанаргүй, ажлаа дутуу хийсэн, тоо хэмжээ дутсан хугацаандаа хүлээлгэн өгөөгүй, хүлээн авсан ажил нь сайжруулах шаардлагатай, урсгал зардалд зарцуулсан зөрчил түгээмэл байна. Тухайлбал:

- Алтай оргил констракшн ХХК-ны Зэрэг суманд ойн зурваст хайс хийх 29.6 сая төгрөгийн гэрээгээр гүйцэтгэсэн ажил нь хүлээж авсан хурлын тэмдэглэл, бусад баримт бичиг дутуу, ажлын даалгаврын тоо хэмжээнээс 7.1 сая төгрөгийн ажил дутуу чанаргүй хийж гүйцэтгэсэн, хийсэн ажил нь сайжруулах шаардлагатай,



- Элгэн Итгэл Сэтгэл ХХК-ны Чандмань сумын төвийн гэр хороололд хүүхэд залуучуудын чөлөөт амралтын талбай байгуулах 71.8 сая төгрөгийн гүйцэтгэсэн ажил гүйцэтгэлийн тайлан байхгүй, е-баримтгүй гүйлгээ хийсэн, алданги тооцоогүй, чанаргүй хийгдсэн, гүйцэтгэсэн ажлаа сайжруулах шаардлагатай



- Био риажент ХХК-ны Дуут сумын ЕБ-ийн сургуулийн 10.0 сая төгрөгийн бие засах газар барих гэрээгээр хэрэгжүүлэх ажлыг одоо хүртэл хийж хэрэгжүүлээгүй гэрээний үүргээ биелүүлээгүй төсвийн хөрөнгө үргүй зарцуулсан, гүйцэтгээгүй ажлын урьдчилгаа 7.0 сая төгрөгийг санд буцаан төвлөрүүлээгүй
- Ундрал алт ХХК-ны Тулгийн 30 айлын орчмын тохижилт батлагдсан төсөв болон гэрээний дүнгээс илүү санхүүжилт нэмэлт гэрээ хийж олгосон, зураг төсөв хэт өндөр, ажлын тоо хэмжээгээр хийгээгүй өөрчилсөн,
- Алтайн оргил констракшн ХХК-ны 38.5 сая төгрөгийн өртөгтэй Зэрэг сумын Бураа багийн төвийн их засварын ажил үүрэг даалгаврын биелэлт байхгүй, е баримтгүй гүйлгээ хийсэн, хүлээн авсан хурлын тэмдэглэл байхгүй, гүйцэтгэсэн ажил нь сайжруулах шаардлагатай,

- Жаргалант сумын Бичигт, Тахилт багийн цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа өндөрлөх 00 хийх хогийн цэг хийхээр гэрээ байгуулсан 29.3



сая төгрөгийн өртөг бүхий Од пропортиз ХХК-ны гүйцэтгэсэн гэрээт ажил гүйцэтгэлийн явцын хяналт хэрэгжүүлээгүй, ажлаа бүрэн хийгээгүй алданги тооцоогүй, чанаргүй, ажлын тоо хэмжээ дутуу хийж гүйцэтгэн төсвийн үргүй зардал гаргасан, цэцэрлэгт хүрээлэнг хариуцах эзэнгүй хөрөнгө эзэнгүйдэж байгаа ихэнх ажлаа бүрэн хийж гүйцэтгээгүй орхисон, газрын гэрчилгээ гараагүй, ашиглалтын дараах зардал төсөвт тусгаагдаагүй, хөрөнгө орлого аваагүй,



- Дарви өргөө ХХК 18.9 сая төгрөгийн өртөг бүхий Жаргалант сумын Бичигт, Тахилт багийн цэцэрлэгт хүрээлэнд 2-5 насны хүүхдийн тоглоом тавих ажил ЗХЗ зардал суутгаагүй, ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй, тоглоомын чанар стандарт шаардлага хангаагүй, эвдэрч хэмхэрсэн, гүйцэтгэлийн дараах хяналт хэрэгжүүлээгүй, хөрөнгө эзэнгүйдсэн, ашиглалтын зардал болон харуул хамгаалалтын зардал төсөвт тусгаадаагүй, хүүхдийн аюулгүй байдал хангаадаагүй төсвийн үрэлгэн зардал гаргасан
- Улаан бүрд ХХК-ны 300.0 сая төгрөгийн өртөг бүхий аймгийн ЕБС-ийн сурагчдын ширээ, сандлын шинэчлэл хийх ажлын эрүүл ахуй стандарт шаардлага хангасан эсэх дүгнэлт байхгүй, хөрөнгийн орлого авсан жагсаалт хуваарилалт тодорхойгүй, гүйцэтгэлийн явцын хяналт хэрэгжээгүй байгаа
- Алтайн оргил констракшн 41.5 сая төгрөгийн өртөг бүхий ХХК-ны цэвэр усны станцын засварын дэмжлэг Тэмүүлэх гал ХХК ариутгах татуургын дамжуулах станцын засвар хийх ажлын гүйцэтгэлийн дараах хяналт хэрэгжүүлээгүй
- Тахидаг хар ХХК-ны 19.5 сая төгрөгийн өртөг бүхий 30 айлын орон сууцны урд талбайн тохижилт ажлын гүйцэтгэл дутуу, ажлын тоо хэмжээ өөрчилсөн, ажлын даалгавраар ажлаа бүрэн хийж өгөөгүй, зарим ажлууд дутуу хийгдсэн, гүйцэтгэлийн дараах хяналт хэрэгжээгүй, ажлын тоо хэмжээ өөрчилсөн, /резин талбай 1876,8 мянган төгрөг, нэг сандал дутуу 135.0 мянган төгрөг, нэг хогийн сав дутуу 80.0 мянга төгрөгийн хөрөнгө дутуу хийсэн / хийсэн ажил нь сайжруулах шаардлагатай. Тендер өөр хүнд дамжуулсан
- Тахидаг хар ХХК-ны 48.9 сая төгрөгийн өртөг бүхий Ургамал захын дээд талын талбайн тохижилтын ажлууд хугацаандаа ажлаа бүрэн хийгээгүй, ажлын гүйцэтгэл дутуу, алданги тооцоогүй 2056.3 мянган төгрөг, явцын хяналт хэрэгжээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй
- Нью зест ХХК-ны Баян булаг зуслангийн их засвар болох 21.0 сая төгрөгийн өртөг бүхий ажил тендер зарлаагүй шууд гэрээ хийсэн, МА-ын зардал төсөвт өртөгт байгаа, дутуу ажлын гүйцэтгэл байхгүй, ЗХЗ суутгаагүй, гүйцэтгэлийн дараах хяналт хэрэгжээгүй, ажлаа чанаргүй хийсэн, маргаантай байгаа. Хийсэн ажлын гүйцэтгэл хангалтгүй, төгсөгчдийн хандиваар хийсэн ажил давхардсан, ажлаа сайжруулах шаардлагатай байгаа нь төсвийн тухай хуулийн 24.4³-ийг зөрчсөн
- Шандны ус ХХК-ны Баян булаг зуслангийн амралтын барилгын их засварын 56.4 сая төгрөгийн өртөг бүхий гэрээт ажил гүйцэтгэл хангалтгүй, МА-ын акт шаардлага хангахгүй, явцын хяналт хэрэгжээгүй, ажлаа чанаргүй гүйцэтгэсэн хийсэн ажил нь сайжруулах шаардлагатай,



2.1.5 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний цөөн хэд нь үр дүнтэй, сайн хэрэгжсэн ч дийлэнх хөтөлбөр төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, холбогдох хууль, журамд нийцээгүй байна. Тухайлбал:

- Аргалант мөнхөд ногоон ХХК-ны 7.0 сая төгрөгийн "Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх" хөтөлбөр гэрээний үүргийн биелэлт хангалтгүй гүйцэтгэлийн тайлан байхгүй, хүлээн авсан актгүй, явцын хяналт хэрэгжүүлээгүй, үр дүнг тооцсон

³ "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно"

- гэрээ дүгнээгүй, е баримтгүй ажил гүйлгээ хийсэн, эргэн тооцож дараагийн иргэдэд боломж олгоогүй, төсвийн үргүй зардал гарсан
- Гулзатын шил ХХК-ны 30.0 сая төгрөгийн иргэд аж ахуй нэгжүүдийн зоорь засварлах захирамжийн хэрэгжилт хангалтгүй гүйцэтгэлийн тайлан байхгүй, хүлээн авсан актгүй, тараасан баримтгүй, эргэн тооцох эсэх тодорхой бус, зориулалт бус зарцуулж төсвийн үргүй зардал гаргасан үр дүнг тооцоогүй
 - Экологийн боловсрол олгох бүсчилсэн сургалтын зардлын захирамжийн хэрэгжилт хангалтгүй гүйцэтгэлийн тайлан байхгүй, хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцоогүй
 - АЗЗА ТӨХК-ны Цайны зам хотын түүх бүс нутгийн төв голомт цогцолборын талбай бэлтгэх ажлын гүйцэтгэл хангалтгүй, ЗХЗ суутгаагүй, тэмээгээ одоо хүртэл байрлуулаагүй
 - Үенч, Ховд сумын зорилтод бүлгийн эх хүүхдүүдэд 18.0 сая төгрөгийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн зардал гэж Мөнхцохилхуй эмнэлэгт захирамжаар санхүүжилт олгосон байгаа нь сангийн журмыг зөрчиж хувийн хэвшил,ТББ-ийн хөрөнгө санхүүжүүлж е-баримтгүй гүйлгээ хийсэн, анхан шатны баримт байхгүй байгаа нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.2.4⁴ дэх заалтыг зөрчсөн
 - Залуучуудын суурь судалгаа, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам сэдэвт 15.0 сая төгрөгийн сургалтын зардал захирамжийн хэрэгжилт хангалтгүй анхан шатны баримт байхгүй, хэмнэгдсэн зардал санд буцаан төвлөрүүлээгүй байгаа нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 8-р зүйлийн 8.8⁵ дах заалтыг зөрчсөн,
 - Засаг даргын захирамжаар Энергийн хад Б.Баярхүү 20.0 сая төгрөг, Тэмээний ашиг шим Мянгад чаргагт хоршоо 20.0 сая төгрөг, Савласан тараг сүү Ховд скай ХХК 28.0 сая төгрөг, Мод үржүүлэг Баттөмөр 10.0 сая төгрөг, Банш буузны цех Цагаан шувуут ХХК 10.0 сая төгрөг, Гагнуурын үйлдвэрлэл Тарвагатайн бэлчир ХХК 7.0 сая төгрөг, Сийлбэртэй модон эдлэл 30.0 сая төгрөг, Хүсэл тэмүүллийн дөл Бэлэг дурсгалын эд зүйл 5.0 сая төгрөг, Алтайн нутгийн дээж Ач оюун далай эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмж шинэчлэх 10.0 сая Өв эс ХХК Хими цэвэрлэгээний үйл ажиллагааг өргөтгөх 20.0 сая төгрөг, Аргалант мөнхөд ногоон ХХК-ны 10.0 сая төгрөг, Алтан Хөхий нэгдэл ХХК-ны Сарлаг өсгөх төслийн зээл 20200827А/462 захирамжаар зээл олгож сангийн хөрөнгө зориулалт бус зарцуулсантай холбоотой төсөвт буцаан төвлөрүүлэх 190.0 сая төгрөгийн үр дүнг тооцож гэрээ дүгнээгүй, зээл зээлийн хүү болох 19.8 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн нь төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.5⁶ дахь заалтыг зөрчсөн
 - Шинэ эвлэл ХХК-ны Сэтгүүлчдийг чадавхжуулах 30.0 сая төгрөгийн захирамжийн хэрэгжилт хангалтгүй сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл иж бүрэн биш, сангийн хөрөнгө зарцуулах журам зөрчсөн
 - Аймгийн брэнд бүтээгдэхүүн сурталчлах 14.9 сая төгрөгийн захирамжийн хэрэгжилт хангалтгүй хүлээн авсан актгүй, гэрээний дүгнэлтгүй, гүйцэтгэлийн тайлан байхгүй, зарцуулсан баримтгүй
 - ОНХС-гийн хөрөнгийг төрийн албан хаагчид, Иргэдийн хурлын төлөөлөгчид, эмэгтэйчүүд, залуучуудыг чадавхжуулах, туршлага судлах, сургалт зохион байгуулах нэрийдлээр баяр наадам, тэмцээн уралдаан зохион байгуулдаг, шагнал

⁴ Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал" олгох,

⁵ "ОНХС-ийн тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ"

⁶ "Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах"

урамшил, тусламж, дэмжлэг олгодог, батлагдсан хөтөлбөр, төсөвгүй байтал зардал гаргадаг зэрэг сангийн хөрөнгийг зориулалт бусаар, үр дүн тодорхойгүй, түүнчлэн журмаар хориглосон арга хэмжээнд зарцуулсан

- Ховд ЗДТГ Мэдээлэл солилцооны "ХУР" системийн төрийн цахим үйлчилгээний төвийн байрны халаалтын зардал захирамжийн хэрэгжилт хангалтгүй зориулалт бус зарцуулж төсвийг үр ашиггүй зарцуулсан, Тахидаг хар ХХК-ны Хур системийн төвийн байрны халаалт хийх ажил хүлээлгэн өгсөн актгүй байгааг дахин хянаагүй
- Жаргалант сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, гэрээний үүргээ зөрчсөн, хөндлөнгийн хяналт хэрэгжээгүй, магадалшгүй ажлыг хүлээн авсан актаар баталгаажуулаагүй, төсвийн хөрөнгө үргүй зарцуулсантай холбоотой 3.8 сая төгрөгийн зөрчил
- Жаргалант сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажил шаардлага хангахгүй, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй, зарим ажил акт баримтаар баталгаажаагүй, орлого аваагүй, хийсэн ажил чанаргүй ажлаа дутуу хийсэн, хугацаандаа хүлээлгэн өгөөгүй, хүлээн авсан ажил нь сайжруулах шаардлагатай 167.1 сая төгрөгийн зөрчил
- Жаргалант сумын ОНХО, ОНХС-ийн өмнөх онуудад төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтууд эвдэрч сүйдсэн хариуцах эзэнгүй, хөрөнгийн орлого шийдвэрлээгүй, хөрөнгийн үр ашиг үр дүн буурсан
- Жаргалант сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажил шаардлага хангахгүй, эргэн тооцох нөхцөлгүй төсөв зарцуулсан, чанаргүй, ажлаа дутуу хийсэн, хугацаандаа хүлээлгэн өгөөгүй, хүлээн авсан ажил нь сайжруулах шаардлагатай, сангийн хөрөнгийг урсгал зардалд зарцуулсан 670.3 сая төгрөгийн зөрчлүүд байна.

Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ажлуудын чанар хангалтгүй, ажлын даалгавар, зураг төсвийн дагуу хийгдээгүй, чанарын баталгаат хугацаанд эвдрэл гэмтэл гарч байна.

2.1.6 2019 онд Хөшөөт хөгжил сан нь 1264.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж 1508.8 сая төгрөгийн 43 төсөл, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлжээ.

2020 онд 1234.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж 1293.9 сая төгрөгийн 46 төсөл, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлжээ.

Аймаг, сумдын хувьд төсөвт байгууллага болон холбогдох газруудаас ирүүлсэн Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг хурлаар хэлэлцэж ач холбогдлоор нь эрэмбэлж хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон эсэх нь баримтаар нотлогдохгүй байгаа бөгөөд төлөвлөлтийн талаар судалгаа шинжилгээ хийсэн баримт материал байхгүй байна.

2019 онд Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжүүлэх 57 ТАХ тодотгосноос сум, байгууллагад эрх шилжин зохион байгуулсан ажил 24, үүнээс шинээр эхлэх хөрөнгө оруулалтад 2 ажил, тоног төхөөрөмж худалдан авахад 13 ажил, урсгал засварт 9 ажлын эрхийг тус тус шилжүүлжээ. 2019 оны хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- *Ховд аймгийн Зэрэг сумын цэцэрлэгийн хашааны тохижилтын ажлыг Асьфа констракшн ХХК шалгарч 2018.12.04-2019.05.10-ны хооронд гүйцэтгэхээр аймгийн Засаг даргын орлогчтой 12.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулж 8.6 сая төгрөгийн санхүүжилт авч хашааг барьсан боловч ажлын даалгаврын дагуу хийгээгүй барьсан модон хашаа нь салхинд нурсан, гэрээт ажлаа одоог хүртэл комисст хүлээлгэж өгөөгүй байна.*



2.1.7 Батлагдсан арга хэмжээний тендерийн хэмнэлтийг зарцуулсан байгаа нь Сангийн сайдын 415 дугаар тушаалаар баталсан журмын холбогдох заалтуудтай зөрчилдөж байна.

Зарцуулаагүй үлдэгдэл буюу хэмнэлтийг захирамж гарган төсөв төлөвлөгөөнд тусгагдаагүй төгсөгчдийн хөшөөний дэмжлэгт 6.6, Татварын хэлтэст санхүүгийн дэмжлэг 1.0, Зооноз өвчин судлалын төвийн авто машины засвар үйлчилгээний зардал 4.1 сая төгрөгийг тус тус урсгал зардалд гүйлгэн зарцуулжээ.

2.1.8 Засгийн газраас баталсан жишиг хэмжээг мөрдөөгүйгээс баяр наадмын зардлыг 30.0 сая төгрөгөөр илүү төлөвлөж баталж зарцуулжээ.

Засгийн газрын 271 дүгээр тогтоолоор Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг байхаар тогтоосон байхад Хөшөөт хөгжил сангаас Аймгийн баяр наадам зохион байгуулах арга хэмжээний зардал 40.0 сая төгрөг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж зарцуулжээ.

2.1.9 Аймгийн ИТХ-ын 11/02 тоот тогтоолоор Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтад баталсан 2308.3 сая төгрөгийн 66 төсөл арга хэмжээнээс 1293.9 сая төгрөгийн 46 төсөл, хөтөлбөр арга хэмжээг тайланд онд санхүүжүүлсэн байна.

Ковид-19 цах тахлын улмаас 2020 оны 2-5 сарын хооронд Мон Эн Ко ХХК-ны нүүрсний экспорт зогссонтой холбоотой орлогын төлөвлөгөө тасарсан ба тухайн онд хэрэгжихээр төлөвлөгдсөн 13 хөрөнгө оруулалт хөтөлбөр арга хэмжээ он дамжсан, 10 ажил тодотголоор төлөвлөгөөнөөс хасагджээ. 2020 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтуудын ажилд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- *Ховд хотын түүхэн онцлогийг харуулсан бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг 89.8 сая төгрөгөөр Зураач урчуудын холбоо ГҮТББ 3 тэмээ, 1 нохойны хөшөө хийж хүлээлгэн өгсөн ба байрлуулах газар нь шийдэгдээгүйн улмаас айлын хашаанд хадгалагдаж байна.*



2.1.10 Хөтөлбөр төсөл арга хэмжээнээс хөрөнгө оруулалтын бус шинжтэй урсгал зардлууд санхүүжүүлжээ.

Төсвийн тухай хуулийн 4.1.24."хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг; хэлнэ гэсэн заалтуудтай нийцэхгүй хөрөнгө оруулалтын бус шинжтэй дараах зардлуудыг тус тус төлөвлөж санхүүжүүлжээ.

- Хууль эрх зүй, үйл ажиллагааны мэдээлэл сурталчилгааны зардал хөтөлбөрөөс төсөв төлөвлөгөөнд тусгаагүй чанарын менежментийн тогтолцооны ISO 9001 стандарт нэвтрүүлэхтэй холбоотой 43.0 сая төгрөгийн зардлыг захирамжаар санхүүжүүлсэн.
- Засгийн газрын 271 дүгээр тогтоолоор Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг байхаар тогтоосон байхад Хөшөөт хөгжил сангаас Аймгийн баяр наадам зохион байгуулах арга хэмжээний зардал 14.6 сая төгрөг аймгийн техник хяналтын зардлын дансанд шилжүүлж зарцуулсан байна.

2.1.11 Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтад баталсан 201.5 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээнээс 192.6 сая төгрөгийн 10 төсөл, хөтөлбөр арга хэмжээг тайланд онд санхүүжүүлсэн байна.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлууд нь үр дүнтэй ажлууд хийгдэж хөрөнгө оруулалтын ажлуудыг холбогдох байгууллагууд нь данс бүртгэлд тусган ажиллажээ.

2.1.12 Замын сангийн хөрөнгө оруулалтад баталсан 750.0 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээнээс 660.1 сая төгрөгийн 12 төсөл, хөтөлбөр арга хэмжээг тайланд онд санхүүжүүлсэн байна.

Засаг дарга данснаас Захиргааны ерөнхий хууль болон бусад эрхийн актуудыг зөрчин дараах зардлуудыг санхүүжүүлжээ.

- ШШГГ-ын цалингийн шийдвэртэй нөхөн олговорт Хөшөөт хөгжил санд 16591.5 мянга, Засаг дарга данснаас 58824.3 мянга, нийт 75415.8 мянган төгрөг төлөвлөж Засаг даргын А/711 тоот захирамжаар аймгийн ЗДТГ-ын нэмэлт дансанд шилжүүлж тус тус санхүүжүүлсэн нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна. Шүүхийн шийдвэрүүдээр сан болон Засаг дарга данснаас олгогдсон 75415.8 мянган төгрөгийг Захиргааны ерөнхий хуульд зааснаар ТЕЗ-ийн дотоод аудитын нэгж хариуцан барагдуулах байтал аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба энэ үүргээ биелүүлээгүй байна.
- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврээр зорчсон унааны хөнгөлөлтийг олгохдоо бодит гүйцэтгэлээр олгоогүй, Бат хөсөгтөн ХХК-ны гаргаж ирүүлсэн гүйцэтгэлээр сар сард олгожээ. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврээр зорчих цахим карт нэвтрүүлэх замаар бодит гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож хэвших. Бат хөсөгтөн ХХК-тай гэрээг шинэчлэн байгуулж нийтийн тээврээр ард иргэдийг зорчих асуудлыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэрэгжилтийн явцын тайланг дээд шатны байгууллагад хүргүүлсэн ч үр дүнг хэлэлцүүлээгүй байна.

2.2.1 Аймгийн сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээг төлөвлөх ажлын хэсэг нь багуудаас ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэн, орон нутгийн бодлого чиглэл, холбогдох журамд нийцүүлэн төсөл, арга хэмжээнд төлөвлөж байгаа хэдий ч ажлын баримтын иж бүрдэл, тэмдэглэл хангалтгүй байна. Тухайлбал: Жаргалант сум, Манхан сум, Зэрэг сум, Цэцэг сум Иргэдээс санал авах, эрэмбэлэх, эрэмбэлэгдсэн саналыг Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн санал хураах, түүнчлэн багуудаас эрэмбэлэгдсэн саналыг сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хэлэлцэж шийдвэрлэсэн тэмдэглэл, үйл ажиллагааны баримт, мэдээллүүд бүрэн бус байна.

2.2.2 ОНХС-ийн төсөв хэлэлцэж батлуулахдаа "Аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дүгнэлт, аймгийн Засаг даргын шийдвэр, хяналт хэрэгжүүлсэн байгууллага, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан хяналт шалгалт, үнэлгээ хийсэн тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг тухайн шатны ИТХ-аар бүрэн хэлэлцүүлнэ" гэж заасны дагуу хэлэлцүүлж хэвшээгүй байна.

2.2.3 ОНХО, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийг аймгийн ЗДТГ-аас сэтгүүл болон Ховд аймгийн цахим хуудас болон аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн цахим хуудсаар дамжуулан ард иргэдэд мэдээлж байна.

ОНХС-гаар хэрэгжүүлэх ажлын тоо хэмжээ, барааны техникийн тодорхойлолт, ажил үйлчилгээний даалгаврын нөхцөл, шаардлага зэргийг оновчтой, бүрэн тодорхойлж худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

2.3.1 ОНХС-гийн хөрөнгөөр 2020 онд өмнөх оноос шилжсэн 799.1 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ, шинээр эхлэх 5319.0 сая төгрөгийн 130 төсөл арга хэмжээг, өмнөх оноос 293.3 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 94 төсөл арга хэмжээнд 4143.5 сая төгрөг төлөвлөснөөс 2860.8 сая төгрөгийн өртөг бүхий 26 арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалт, 74.0 сая төгрөгийн 2 арга хэмжээг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаагаар, 128.5 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 2687.2 сая төгрөгийн 49 арга хэмжээг шууд гэрээ байгуулан хэрэгжүүлжээ. Жаргалант сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 120.7 сая төгрөгийн 6 ажил харьцуулалтын аргаар, 168.7 сая төгрөгийн 17 ажлыг шууд худалдан авалтаар хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний дийлэнхийг шууд гэрээ байгуулан ажиллаж хэт жижиглэн хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр өгөөжид сөргөөр нөлөөлж байна.

2.3.2. Тендер шалгаруулах үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим системд байршуулан иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлсэн ч зарим ажлуудыг худалдан авах ажиллагааны хууль, журамд нийцүүлээгүй байна. Тухайлбал:

- *Эвлэл ХХК-ны Ховд суманд шинээр худаг гаргах 18.9 сая төгрөгийн өртөг бүхий ажил гүйцэтгэлийн тайлан байхгүй, е-баримтгүй ажил гүйлгээ хийсэн, ЗХЗ, барьцаа хөрөнгө суутгаагүй, төсөвт өртөг байхгүй,*

- Гранд пасикал ХХК-ны Дулаан дамжуулах 8 дугаар төвийн дулааны шугам холбох 74.0 сая төгрөгийн ажил барьцаа хөрөнгө аваагүй, ЗХЗ байхгүй, гүйцэтгэлийн тайлан байхгүй, төсөвт өртөг тодорхойгүй,
- 320 айлын гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбох 120.0 сая төгрөгийн ЦДАШ Цамбагараа багт шилжүүлэх ажил хугацаандаа хүлээлгэн өгөөгүй, өмнөх санхүүжилтийг хэрхэн тооцсон эсэх тодорхой бус, хөрөнгийн орлого шийдвэрлээгүй, өмнөх алданги тооцсон актын төлбөр барагдуулаагүй, хяналт хэрэгжүүлээгүй
- Гайхамшинт өнгө ХХК Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж 18.9 сая төгрөг /шууд худалдан авалтаар
- Мөнхбуян эрдэнэ ХХК-ны Нутгийн удирдлагын ордны дээврийн засвар болох 20.0 сая төгрөгийн ажил зураг төсөлгүй, МА-ын зардал тусгаагүй, е-баримтгүй гүйлгээ хийсэн, ажлын даалгавар байхгүй,
- Элбэгтүн ХХК 2-р цэцэрлэг сантехник засвар Б.Бизьяа 18.0 сая төгрөгийн тендер зарлаагүй дутуу ажлын актгүй, гүйцэтгэлийн дараах хяналт хэрэгжээгүй
- Ньюзест ХХК-ны баянбулаг зуслангийн их засвар 21.0 сая төгрөгийн ажил тендер зарлаагүй, МА-ын зардал төсөвт өртөгт байгаа, дутуу ажлын актгүй, ЗХЗ суутгаагүй, гүйцэтгэлийн дараах хяналт хэрэгжээгүй
- Гулзатын шил ХХК-ны Иргэд аж ахуй нэгжүүдийн зоорь засварлах 30.0 сая төгрөгийн өртөг бүхий ажил
- Аж мандалт ХХК-ны гэрээгээр нөөцийн гурил нийлүүлэх 40.0 сая төгрөг
- Баавай өвөө ХХК-ны нөөцийн мах бэлтгэх 117.2 сая төгрөгийн өртөгтэй
- Гүрт богд ХХК тос, элсэн чихэр, гурил нийлүүлэх 18.6 сая төгрөг
- Монголиан катл ХХК нөөцийн мах нийлүүлэх шууд гэрээ 135.0 сая төгрөг
- Сая хүч ХХК-ны хот тохижуулахын авто граж байгуулах 27,7 сая төгрөгийн ажил
- Бат дайчин ХХК-ны бичигт багт гудамж тайлбай тохижуулах 21.3 сая төгрөгийн ажил

2.3.3 ОНХО-аар хэрэгжүүлсэн ажлуудаас 2019 онд нээлттэй тендер шалгаруулалтаар 355.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг, харьцуулалтын аргаар 395.0 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээг, шууд худалдан авалтаар 131.5 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн.

2020 онд нээлттэй тендер шалгаруулалтаар 70.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг, харьцуулалтын аргаар 280.5 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг, шууд худалдан авалтаар 555.9 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээг санхүүжүүлжээ.

Засгийн газрын баталсан босго үнээс давсан 2019 онд 75.0 сая төгрөгийн Эв эеийн хүч худалдааны төвийн халаалтын ажлыг халаалтын улирал эхлэх болон үйл ажиллагаа эхлэх болсонтой холбоотойгоор аймгийн Онцгой комиссын шийдвэр гарч шууд худалдан авалтын аргаар гүйцэтгэгч байгууллагыг шалгаруулжээ. 2020 онд аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 411.0 сая төгрөгийн 5 ажилд шууд гэрээ байгуулан ажиллажээ.

- 2020-03-26 №04 тоот ОК-ын шийдвэрээр шаргуугийн услалтын системийг ОНХО-аас Оргил өнөр ХХК-тай 99.9 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулан 2020-12-14-ны өдөр хүлээн авсан боловч далангийн ажил нь нь сэтэрсэн байна.

БҮЛЭГ 3. Мэргэжлийн байгууллага болон захиалагчийн зүгээс хөрөнгө оруулалтын ажлуудад хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс чанаргүй ажлууд хийгдэж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгийн гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагууд болон захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1.1 Иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавих, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлээгүй, аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хорооны ажлыг сайжруулах шаардлагатай байна. Сангийн яамны сайтад тавьсан мэдээллээс иргэдийн санал авсан нь тодорхой харагдахгүй, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын зургийг байршуулаагүй байгаа нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тогтоолын 9.5⁷-дахь заалт хэрэгжээгүй байна.

3.1.2 Аймгийн болон сумдын ОНХС-гийн хэрэгжилтийн үр дүнд Хяналт шинжилгээ, үнэлгээний алба, ХОХБТХ-ээс хэрэгжүүлсэн хяналт байхгүй байгаа нь Сангийн сайдын 228 тоот тушаалын 9.5⁸ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй гэж үзэхээр байна. Тухайлбал:

- *ХОХБТХ-ээс захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга, байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулан арга хэмжээ авсан тайлан ирүүлээгүй,*
- *Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс ямар нэгэн хяналтыг хийсэн талаар аудитын хугацаанд тайлан мэдээллийг ирүүлээгүй,*
- *Тогтвортой амьжиргаа төсөл-3, Сангийн яамтай хамтран ОНХС-гийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тайлан ирүүлээгүй*

3.1.3 2019 онд Техник хяналтын зардлын дансанд хөрөнгө оруулалтын ажлуудаас 557.4 сая төгрөгийн хяналтын зардлын орлого орж 296.9 сая төгрөгийг хяналтын үйл ажиллагаанд зарцуулжээ. 2020 онд 563.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж 375.4 сая төгрөгийн хяналтын зардлыг санхүүжүүлжээ.

Техник хяналтын зардлаас хяналт, шалгалттай холбоогүй ажил гүйлгээг санхүүжүүлжээ. Үүнд:

- *Техник хяналтын зардлаас Эв эеийн хүч худалдааны төвийн цахилгааны засварыг 2020 онд 19.7 сая төгрөгөөр Тахидаг хар ХХК-тай гэрээ байгуулан хүлээн авсан боловч хуучин цахилгаан халаалтын зарим тоног төхөөрөмж, цахилгааны утас алга болсон байна.*

⁷ Аймаг нийслэлийн ЗДТГ нь аймаг нийслэлийн түвшинд ОНХС-ийн хэрэгжилтийг санхүүгийн болон бусад хяналт шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтээр мэдээллийн сан байгуулах, мэдээллийн санг холбогдох мэдээллээр тогтмол баяжуулж байх..

⁸ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ.

- 2020 онд техник хяналтын зардлаас хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн сургалтын зардалд 1.6 сая, ГХБХБГ-т ISO стандарт нэвтрүүлэхтэй холбоотой 8.5 сая төгрөгийг хяналтын бус үйл ажиллагаанд зарцуулжээ.
- 2019 оны техник хяналтын зардлаас Манхан сумын ЭМТ-ийн сантехникийн засварын ажилд 10.0 сая, Эсбагийн орон сууцны сантехникийн засварт 42.5 сая төгрөгийг зарцуулсан.
- 2020 онд техник хяналтын зардлаас Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ын 17-р ДДТ-ийн өргөтгөлийн ажлыг Ховд дулааны станц ТӨХК, Шим-Ус ОНӨААТҮГ нар хамтран 61.7 сая төгрөгөөр засварласан боловч данс бүртгэлд тусгаагүй байна.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнд дүгнэлт хийж, нэгдсэн бодлого, чиглэлээр хангаагүй байна.

3.2.1 Аймаг сумдын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн боловч аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнд дүгнэлт хийж, нэгдсэн бодлого, чиглэлийг аймгийн Засаг даргын шийдвэрээр хүргүүлж хэвшээгүй нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө нь сангийн гол зорилгодоо уялдахгүй, нэгдсэн бодлого, чиглэлээр хангагдахгүйгээс сангийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдах эрсдэлийг дагуулж байна.

ОНХС-гийн өмнөх аудитаар илэрсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна

3.2.2 Өмнөх онуудад өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, орон нутгийн удирдлагууд ОНХС-ийн орлогын төлөвлөлт, хуваарилалт, бүрдүүлэлт болон сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулаагүйгээс өмнөх аудитаар илэрсэн зөрчил дутагдал арилахгүй, дараах зөрчлүүд давтан гарсаар байна.

Тухайлбал:

- Аймгийн ОНХС, Жаргалант сум, Зэрэг сум, Чандмань сум, Манхан суманд худалдан авах хууль журам зөрчсөн зөрчлүүд давтан гарсан байна.
- Аймгийн ОНХС болон Жаргалант сум нь өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, авлага бууруулаагүй, өмнөх оны хөрөнгийн асуудал шийдээгүй, сангийн хөрөнгөөр бүрэн хийгдээгүй болон дутуу ажлуудыг дахин баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5⁹-дахь заалт, ОНХС-гийн зааврын 9-р зүйлийн 9.1¹⁰-дэхь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

⁹ Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

¹⁰ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт санхүүжилт гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажил, төсөл хөтөлбөрийг иргэдээр хэлэлцүүлэн гарсан саналыг эрэмбэлж гаргасны үндсэн дээр төлөвлөөгүй, хэт жижиглэсэн, сургалт хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан, үр дүнгийн өгөөжийг тооцоогүй, хэрэгжилтийн явцад тавих захиалагчийн болон иргэдийн хяналт хангалтгүй байснаас ажлын даалгавар, зураг төсвийн дагуу чанартай хийгдээгүй байдал түгээмэл болсон
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлууд ихэнх нь арчилгаа урсгал засвар хийгдээгүйгээс хуучирч муудсан, болон зам сэтэлж байгаа аж ахуйн нэгжүүд замаа засдаггүйгээс эвдэрч сүйдсэн, хөрөнгө оруулалтын үр ашиг буурсан байна. Тухайлбал: Ховд аймагт шинээр ашиглалтад орсон орон сууцуудын нийтийн эзэмшлийн талбай, ногоон байгууламж, тоглоомын талбайгүй хүлээн авч дараа нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байна. Төрийн болон хувийн хөрөнгөөр барилга, байгууламж барьж байгаа аж ахуйн нэгжүүд нь машин механизмаар төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилтын ажлыг эвдэж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна. Жаргалант сумын шинэ байрыг нээгдсэн дулаантай холбох, прогресс сургуулийн хажуугийн орон сууцны бохирын шугамыг засварлах, Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ын ахуй үйлчилгээний барилгын замын эсрэг талын байрыг дулаантай холбохоор авто замыг сэтэлсэн боловч буцаан засаагүй байна.
- Шандны ус ХХК гүйцэтгэсэн Хайрхан багийн хүүхдийн тоглоомын талбай, авто машины зогсоол барих ажил болгон өөрчилсөн ч одоог хүртэл бүрэн хийгдээгүй байна
- Онхот булаг ХХК Мөнххайрхан сумын ковш нийлүүлэх өмнөх оны ажил болох зардлаас ЗХЗ суутгасан эсэх тодорхой бус, урьд оны тооцоо хийсэн актгүй, хугацаа яагаад хэтэрсэн алданги тооцоогүй шалтгаан, одоо ажиллахгүй байгааг яаж шийдвэрлэх нь тодорхой бус 13.6 сая төгрөг,
- Буянт тэгш үйлс ХХК-ны урьдчилж гарсан 10.1 сая төгрөгийн гэрээт ажлын явцын хяналт хийгдээгүй, гүйцэтгэлийн тайлан байхгүй, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдсан
- Цацаг ХХК-ны өмнөх оны 37.4 сая төгрөгийн ажил хүлээн авсан актгүй, хугацаа хэтэрсэн гэрээний үүргээ биелүүлээгүй
- Иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл, арга хэмжээг ОНХС-ийн төлөвлөгөөнд тусгахгүй байх зөвлөмж удаа дараа өгсөн боловч алдаа, зөрчил давтагдсаар байна.



Өмнөх оны ОНХО-ын аудитаар 17.6 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 621.4 сая төгрөгийн 1 албан шаардлага, 88.6 сая төгрөгийн 5 зөвлөмж өгөгдсөнөөс төлбөрийн актыг бүрэн барагдуулан өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан боловч 621.4 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаар нийт 2500133.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 149415.5 мянган төгрөгийн 6 төлбөрийн акт, 888380.0 мянган төгрөгийн 8 албан шаардлага, 1462339.0 мянган төгрөгийн зөвлөмж бичигдлээ.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

- **Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөн холбогдох хууль, журмыг зөрчин, баталжээ.**
- **Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, хэрэгжилтийн явцын тайланг дээд шатны байгууллагад хүргүүлж үр дүнг хэлэлцээгүй, хөрөнгө оруулалтын ажлууд нь үр дүнтэй болоогүйгээс төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулжээ.**
- **Захиалагчийн зүгээс хөрөнгө оруулалтын ажлуудад хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс чанаргүй ажлууд хийгдэж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулжээ.**

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди-д зөвлөх нь

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээнд нэгдсэн журмаар мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоог бүрдүүлэн хяналт хэрэгжүүлж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэн, хяналт хэрэгжүүлэн ажиллах
2. Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй хөтөлбөр, арга хэмжээг аймгийн ИТХ-аар баталдаг байдлыг таслан зогсоох
3. Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг хариуцах эзэнтэй болгож, цаашид гарах урсгал зардлыг төсөвт тусгуулан хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх талаар бодлогын шийдвэр гаргах

Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав-т зөвлөх нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж гэрээний үүргээ биелүүлэхгүй байгаа аж ахуйн нэгжүүдэд хариуцлага тооцох
2. ОНХС-аас болон төсвөөс олгож байгаа зээлийн гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж үр дүнг олон нийтэд мэдээлэх

Санхүү Төрийн Сангийн хэлтсийн дарга Ч.Багдал-д

1. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо гүйцэтгэгчийн тендерт шалгарсан үнийн дүн бүхий анхны гэрээг баримтлан бодит гүйцэтгэлд үндэслэн үүрэг даалгаврын биелэлтээр санхүүжүүлж байх
2. Ковидтой холбоотой аймгийн нөөцөд нийлүүлсэн бараа нийлүүлэлтийн гүйцэтгэл, буцаж орсон мөнгө хөрөнгийн тооцоог дахин хянаж, зөрчлийг арилгах
3. Техник хяналтын зардлыг хууль, журмыг дагуу зарцуулах, батлагдаагүй арга хэмжээ зарцуулдаг байдлыг таслан зогсоох

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх-д

1. Батлагдсан төсөл арга хэмжээтэй холбоотой судалгааг яамнуудтай нэгтгэж мэдээллийн сан үүсгэж, аудитаас шаардсан мэдээлэл судалгааг хугацаанд нь иж бүрэн чанартай гаргаж байх
2. Эвийн хүч хоршооны дутагдсан хөрөнгийг хуулийн байгууллагад хандан буруутай этгээдийг тогтоолгож учирсан хохирлыг буруутай байгууллагаас гаргуулах
3. Бүтээн байгуулалтын зураг төсвийн ажлын даалгаврыг боловсруулах ажлын үр дүнг сайжруулах
4. Төсөл арга хэмжээний тендерийн бичиг баримт, геологийн дүгнэлт, газар олголт, техникийн нөхцөл зэргийг иж бүрдэл болгосны үндсэн дээр худалдан авах ажиллагаанд шилжүүлж байх
5. Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ын 17-р ДДТ-ийн өргөтгөлийн ажлыг бүртгэлд тусгаагүй ажлыг хэрэгжүүлэх

Буянт сумын Засаг дарга Ч.Нэргүй-д

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Шаргуугийн услалтын системийн толгойн барилгын ажлыг гэрээнд заагдсан баталгаат хугацаанд нь гүйцэтгэгч аж ахуйн нэгжээр чанартай засуулан, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэн ажиллах.

Хөшөөт хөгжил сангийн захирал Т.Мягмардорж-д

1. Батлагдсан зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг сангийн данснаас санхүүжүүлэхгүй байх, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ыг мөрдөн ажиллах.
2. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүнг тооцох, хөрөнгө оруулалтын бус урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байхад анхаарах.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга Э.Дөлбадрах-д,

1.Барилга байгууламжийг зураг төсвийн дагуу гүйцэтгэж байгаа явцад үе шатны хяналтыг сайжруулж, техникийн болон улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлсний дараа ашиглалтад хүлээн авах улсын комиссын акт гарган ажиллах

2. Хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдаж байгаа орон сууцуудын тохижилтын ажил болон ногоон байгууламжийг хийсэн нөхцөлд хүлээн авах, дулааны шугам сүлжээ, цэвэр бохир ус оруулахдаа холбогдон төрийн өмчийн зам, талбайг эвдэлсэн тохиолдолд буцаан засуулан ажиллах

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны дотор гаргаж ирүүлэх

ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР